**НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН**
**2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая.төгрөг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго:** Нийслэлийн мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар төрийн үйлчилгээг цахимжуулах. | | | | | | | |
| **1** | **Зорилт 1.** Нийслэл хотын хяналт удирдлагын цогц систем бий болгож, нийслэлийн мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн байдал, аюулгүй байдлыг хангаж, нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгосон байна. /НХТЖҮЧ-ийн 5.2/ | | | | | | |
| 1.1 | Харилцаа холбоо мэдээллийн дэвшилтэт технологийг ашиглан иргэн төвтэй, ухаалаг үйлчилгээг үзүүлэх, "Цахим засаглал" төсөл хэрэгжүүлнэ. /НЗДҮАХ 4.1.3.1/ | 4,890.0 | Төслийн хэрэгжилтийн хувь | 20% | 70% | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад цахим шилжилт буюу төрийн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, нээлттэй, хүнд сурталгүй хүргэх, засаглалыг сайжруулах чиглэлээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх "Цахим Улаанбаатар" төслийн хүрээнд 7 дэд төслийг 2023 онд хэрэгжүүлэхээр нийслэлийн 2023 оны төсөвт тусгаж батлуулсан. Тус төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны явцад буюу 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Нийслэлийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан болно. | 70% |
| 1.2 | "Цахим засаглал" төслийн хүрээнд Хэсгийн ахлагчийн систем нэвтрүүлэх | - | Нэвтрүүлсэн системийн тоо | - | 1 | Төрийн анхан шатны нэгж болох хороодын хэсгийн ахлагчдын үйл ажиллагааг цахимжуулах "Хэсгийн ахлагчийн систем"- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ийг 2023 оны 1-р улиралд хэрэглээнд нэвтрүүлсэн. Хэсгийн ахлагчийн үйл ажиллагааг цахимжуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг, төлөвлөгөөг нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1488 дугаар захирамжаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөний дагуу нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хороодын 359 албан хаагч, 1535 хэсгийн ахлагч нарт систем ашиглалттай холбоотой 55 удаагийн сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан. Хэсгийн ахлагчийн системээр зөрчлийг бүртгэж НҮНТ-д илгээж, харьяалагдах байгууллагуудад шилжүүлж шийдвэрлэж ажиллаж байгаа бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 2277 зөрчил бүртгэгдсэнээс шийдвэрлэсэн 2258 шийдвэрлэх шатандаа явагдаж байгаа 19 байна. Шийдвэрлэсэн 2258 зөрчлийн шийдвэрлэлтийн дундаж хугацааг тооцоход 10 хоног, 3 цаг, 56 минут байна.<br>Энэхүү төслийн санхүүжилт "Нийслэлийн 2023 төсөвт өөрчлөлт оруулах тухай" Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан болно. | 70% |
| 1.3 | "Цахим засаглал" төслийн хүрээнд Digital UB гар утасны аппликейшны хөгжүүлэлт | - | Нэвтрүүлсэн аппликейшны тоо | - | 1 | Төр, иргэн, аж ахуй нэгж байгууллага хоорондын харилцааг шинэ түвшинд гаргах, нийслэлийн иргэд өөрт хэрэгтэй бүхий л мэдээ, мэдээллээ цаг хугацаа алдалгүй авах, санал хүсэлт, өргөдөл, гомдол гаргах, татвар, төлбөр хураамжийг төлөх, зэрэг нийслэлийн иргэдэд | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шаардлагатай бүхий л мэдээлэл, үйлчилгээг нэгдсэн байдлаар авах боломж бүхий “Дижитал УБ” гар утасны аппликейшныг хөгжүүлэлт хийгдэж байгаа бөгөөд аппликейшны хөгжүүлэлтийн ажил “Нийслэлийн 2023 төсөвт өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан болно. | |
| 1.4 | “Цахим засаглал” төслийн хүрээнд Онлайн бизнес төвийн нэмэлт хөгжүүлэлт | - | Систем хөгжүүлэлтийн хувь | 50% | 70% | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлдэг төрийн үйлчилгээг цахимжуулах хүрээнд “Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-д 2023 онд Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны 29, Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2, нийслэлийн Онцгой байдлын газар 2, 9 дүүргийн Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн 9 үйлчилгээ буюу нийт 42 үйлчилгээг цахимжуулсан. Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn систем, түүний дэд систем болох "E-Business” платформуудад Нийслэлийн “Онлайн бизнес төв” системээр үзүүлж буй бизнес эрхлэгчдэд зориулсан нутгийн захиргааны 10 байгууллагын нийт 86 үйлчилгээг холбосон. Ингэснээр 3 эх үүсвэрээр иргэн аж ахуй нэгж байгууллагаас хүсэлтийг хүлээн авдаг болсон. Энэхүү төслийн төсөв нь “Нийслэлийн 2023 төсөвт өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан болно. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | “Цахим засаглал” төслийн хүрээнд UB ERP системийн гар утасны аппликейшны нэмэлт хөгжүүлэлт | - | Аппликейшны хөгжүүлэлтийн хувь | 70% | 90% | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн UBERP системийг нийслэлийн 1250 байгууллагын 28,400 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж албан бичгийг 100% цахимаар солилцож байна. "UB ERP" системийн гар утасны аппликейшны хөгжүүлэлтийн техникийн даалгаврыг боловсруулан нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн боловч “Нийслэлийн 2023 төсөвт өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан болно. | 70% |
| 1.6 | “Цахим засаглал” төслийн хүрээнд Нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн сайжруулалт, мэдээлэл солилцох боломжийг бий болгох ажил | - | Систем хөгжүүлэлтийн хувь | - | 100% | Энэхүү төслийн техникийн даалгаврыг боловсруулан нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн боловч “Нийслэлийн 2023 төсөвт өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан ч байгууллагын дотоод нөөц боломжид тулгуурлан “Газар зүйн мэдээлэл MNS 18 багц стандартад нийцүүлэн бүтэц загварыг шинээр бүрдүүлэх”, “Нийслэлийн Хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн өгөгдөл/мэдээллийг Газар зүйн мэдээлэл MNS 18 багц стандартын дагуу хөрвүүлэх” ажлуудыг зохион байгуулан мэдээлэл солилцох боломжийг сайжруулахаар ажиллаж байна. | 90% |
| 1.7 | “Цахим засаглал” төслийн хүрээнд Дата төвийн өргөтгөл, шинэчлэлт, | - | Системийн хөгжүүлэлтийн хувь | - | 100% | Энэхүү төслийн техникийн даалгаврыг боловсруулан нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн боловч | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүй байдал, хяналтын систем | | | | | “Нийслэлийн 2023 төсөвт өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан ч байгууллагын дотоод нөөц боломжид тулгуурлан “Нийслэлийн дата төвийн серверүүдийн холболтын системийг шинэчлэх”, “Нийслэлийн Дата төвийн серверийн нэгдсэн удирдлагын системийг сайжруулах” ажлуудыг Мэдээллийн аюулгүй байдлын газраас өгсөн зөвлөмжийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна. | 90% |
| 1.8 | “Цахим засаглал” төслийн хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага болон төрийн бусад байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, нийслэлийн дата төвд түшиглэн системийн энтерпрайз архитектур боловсруулах | - | Мэдээлэл солилцох сервисийн тоо | - | 5 | Энэхүү төслийн техникийн даалгаврыг боловсруулан нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн боловч “Нийслэлийн 2023 төсөвт өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан ч байгууллагын дотоод нөөц боломжид тулгуурлан UB ERP системд дараахь нэмэлт сайжруулалтын ажлуудыг хийсэн. Үүнд:<br>• Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтантай уулзах цаг захиалах, өргөдөл гомдол, санал хүсэлт гаргах, талархал илэрхийлэх | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боломж бүхий QR дэд системийг нэвтрүүлсэн.<br>• Edoc системээр ирсэн хариутай бичгийн явцын тэмдэглэл хөтлөөгүй тохиолдолд үндсэн арван хоногийн өмнөх ёс дэх хоногт мэдэгдэл ирдэг болгох<br>• Байгууллагын бичиг хэргийн ажилтан өргөдөл бүртгээд шилжүүлэхэд удирдлагын заалт бүртгээд тухайн заалтыг дараагийн өргөдөл гомдолд ашиглах боломжтой болгосон.<br>• QR болон зайнаас цаг бүртгэл хийх боломжийг бүрдүүлсэн. | |
| 1.9 | Хүн ам, ихээр төвлөрдөг газруудыг интернетийн утасгүй сүлжээнд холбосон байна. /НЗДҮАХ 4.1.3.2, НХТЖҮЧ 5.2.4/ | - | Сүлжээнд холбогдсон цэгийн тоо | 6 | 10 | Нийслэлийн хэмжээнд хүн ам ихээр төвлөрдөг номын сан, амралт зугаалгын бүсийн судалгааг гаргаж нийт 20 цэг “Богд хааны ордон музей, Гандантэгчилэн хийд, УБ төмөр замын буудал, Хүүхдийн урлан бүтээх төв, Жуковын хөшөө, музей, Монгол цэргийн музей, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Улсын төв номын сан, Улсын төв номын сангийн салбарууд, Налайх дүүргийн Соёлын ордон Багахангай дүүргийн соёлын ордонд шинээр утасгүй интернетийн үйлчилгээг хүргэхээр тоног төхөөрөмжийн тооцоо судалгаа техникийн даалгавар боловсруулагдсан бөгөөд төсвийн асуудал шийдвэрлэгдээгүй болно. | 70% |
| 1.10 | Иргэн аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээний | - | | 29 байгууллага, 320 | 35 байгууллага, 320 үйлчилгээ | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлдэг төрийн үйлчилгээг цахимжуулах хүрээнд “Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | портал www.emongolia.mn системд холбосон байгууллагын тоог нэмэгдүүлнэ. /НХТ-2023 3.1.2/ | | | үйлчилгээ | | бүртгэлийн систем"-д 2023 онд Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны 29, Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2, нийслэлийн Онцгой байдлын газар 2, 9 дүүргийн Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн 9 үйлчилгээ буюу нийт 42 үйлчилгээг цахимжуулсан. Төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn систем, түүний дэд систем болох "E-Business" платформуудад Нийслэлийн "Онлайн бизнес төв" системээр үзүүлж буй бизнес эрхлэгчдэд зориулсан нутгийн захиргааны 10 байгууллагын нийт 86 үйлчилгээг холбосон. Ингэснээр 3 эх үүсвэрээр иргэн аж ахуй нэгж байгууллагаас хүсэлтийг хүлээн авдаг болсон байна. | |
| **2** | **Зорилт 2.** Гудамж, зам талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор камерын нэгдсэн хяналтын системийг бий болгоно. /НХТЖҮЧ-ийн 7.3/ | | | | | | |
| 2.1 | Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем II шатны төслийг хэрэгжүүлнэ. /НЗДҮАХ 6.3.11.3, НХТ 6.1.15/ | - | Төслийн хэрэгжилтийн хувь | 30% | 50% | "Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем" төсөлд шаардлагатай дэд бүтцийн ажлууд 2022 онд бүрэн хийгдсэн. Тус системийн бүрэлдэхүүн хэсэг болох Автотээврийн хэрэгслийн техникийн цахим гэрчилгээ /RFID tag/-г нийслэлийн хэмжээнд 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 44 цэгээр дамжуулан 442477 ширхэг цахим гэрчилгээг тээврийн хэрэгслүүдэд суурилуулахаар төлөвлөснөөс 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар Автотээврийн үндэсний төвийн техникийн хяналтын үзлэгийн 7 төв, хувийн хэвшлийн 9 төвөөр дамжуулан 75,722 тээврийн хэрэгсэлд суурилуулаад байна. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Нийслэлийн удирдлага, хяналтын цогц системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. /НЗДҮАХ 4.3.1.1, НХТЖҮЧ 7.3.1/ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 18% | 50% | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэж, өгөгдөл, мэдээллийг боловсруулан удирдлагын хяналтын тогтолцоог бүрдүүлэхээр дараах дашбоардуудын модулиудыг хөгжүүлсэн. Үүнд:<br>• Өргөдөл гомдлын дашбоард,<br>• Нийслэлийн аюулгүй байдлын дашбоард,<br>• Хөрөнгө оруулалтын дашбоард,<br>• Нийтийн тээврийн дашбоард,<br>• Замын түгжрэлийн дашбоард,<br>• Нийслэлийн төсөв, санхүүгийн дашбоард гэсэн үндсэн чиглэлийн дашбоардтай байхаар хөгжүүлэлтийг хийсэн.<br>Сити Дашбоардын хөгжүүлэлтийн төсөв “Нийслэлийн 2023 төсөвт өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан болно. | 70% |
| 2.3 | Бичлэг болон зурган мэдээллээс үл давтагдах өгөгдлөөр программ хангамжийг нэвтрүүлэх, гэмт хэргийн цахим зураглал /Griemmap, Compstat/-ыг Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлуудыг хийж, камерыг "Камерын удирдлагын нэгдсэн төв"-тэй холбоно. | - | "Камерын удирдлагын нэгдсэн төв"-д холбосон камерын тоо | 415 | 500 | Нийслэлийн хэмжээнд 2023 онд Улсын төсөв болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн хөрөнгө, дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх нийслэлийн БЗД, СБД, ХУД, СХД, БГД-ийн дүүргүүдийн 609 цэгийн 1586 камерын 28 техникийн даалгавар болон шийдлийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд дээрх камеруудыг “Зам, тээврийн нэгдсэн систем”-ийн камерын хяналтын системд холбохоор ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | /НЗДҮАХ 4.3.1.2, НХТЖҮЧ 7.3.2/ | | | | | | |
| 2.4 | Нийслэлийн Дотоод удирдлагын UB ERP системийн гар утасны аппликейшны нэмэлт хөгжүүлэлт хийнэ. /НХТ 3.1.10/ | - | Системийн гар утасны аппликейшны нэмэлт хөгжүүлэлтийн хувь | 50 | 90 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн UBERP системийг нийслэлийн 1250 байгууллагын 28,400 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж албан бичгийг 100% цахимаар солилцож байна. Энэхүү системийн гар утасны аппликэйшны техникийн даалгаврыг боловсруулан нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн боловч "Нийслэлийн 2023 төсөвт өөрчлөлт оруулах тухай" Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан болно. | 70% |
| 2.5 | Call center дуудлагын төвийг өргөжүүлж дахин загварчлан сайжруулалтыг хийнэ. /НХТ 3.1.11/ | - | Системийн өргөтгөл, сайжруулалтын хувь | 50 | 70 | Нийслэлийн лавлагаа мэдээллийн төв буюу Call center дуудлагын төв 1800-1200 тусгай дугаарт Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв, нийслэлийн Тээврийн үйлчилгээний газар, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Ус сувгийн удирдах газар, ОСНААУГ ОНӨААТҮГ-үүдын тусгай дугааруудыг холбон байнгын ажиллагааны горимоор ажилладаг. "Call center" дуудлагын төвийг өргөжүүлэх тус төсөл, арга хэмжээний техникийн даалгаврыг боловсруулан Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж худалдан авах ажиллагааг зарласан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсөв татагдсан болно. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн иргэдийн өргөдөл, гомдол, саналыг | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүлээн авах, иргэдэд үйлчлэх Call center дуудлагын төв, системийг сайжруулах техникийн даалгаврыг боловсруулан хүргүүлсэн. | |
| 2.6 | Нийслэлийн алслагдсан 3 дүүргийг цахим мэдээллийн нэгдсэн сан, сүлжээнд холбож, дэд бүтэц сайжирсан байна. /НХТЖҮЧ 5.2.1/ | - | Нэгдсэн сүлжээнд холбогдсон дүүргийн тоо | 6 | 9 | Нийслэлийн жил бүрийн төсөвт нэгдсэн сүлжээнд холбогдоогүй алсын 3 дүүргийг холбох төсвийг нийслэлийн төсөвт санал хүргүүлдэг болович төсөв батлагддаггүй бөгөөд нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй Налайх дүүргийн 8, Багануур дүүргийн 5, Багахангай дүүргийн 2 хороодын сүлжээ болон шилэн кабелыг түрээсээр ашиглаж төрийн үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн. | 100% |
| 2.7 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байна. /НХТЖҮЧ 5.2.3/ | - | Цахим аюулгүй байдлыг хангасан хувь | 20 | 70 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хадгалах тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, сүлжээ, серверийн хэвийн найдвартай ажиллагааг хангах нийслэлийн Дата төвд зориулалт бүхий 12 рак, 88 физик сервер, 176 виртуал сервер, хадгалах төхөөрөмж, 130 систем, 278 цахим хуудасны мэдээлэл байрладаг бөгөөд тэдгээрийн хэвийн найдвартай байнгын горимоор тасралтгүй ажиллагааг хангаж ажиллаж байна. | 100% |
| **Зорилт 3. Хуулиар хүлээсэн нийтлэг чиг үүргийн хэрэгжилтийг хангах** | | | | | | | |
| 3.1 | Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах | 1,959.8 сая,төгрөг | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Байгууллагын 2023 оны батлагдсан төсвийн хүрээнд төсвийн тухай хуульд заасны дагуу зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулж, санхүүгийн гүйцэтгэлийн тайланг сар, улиралаар нэгтгэн тухай бүрт нь тайлагнаж ажилласан. Мөн төрийн болон орон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд тавигдах **28** төрлийн мэдээ, мэдээлэл хугацаанд нь байршуулж ажилласан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-тай "Дуудлагын автомашинаар үйлчлүүлэх гэрээ" байгуулсан бөгөөд шаардлагатай тохиолдолд албан хэрэгцээнд дуудлагын авто машин хэрэглэж, байгууллагын батлагдсан төсвийг хэмнэлттэй захиран зарцуулж байна. | |
| 3.2 | Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2023 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 115 дугаар тогтоолоор дараахь төсөл арга хэмжээний төсөв батлагдан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд:<br>1.Нийслэлийн Замын сангийн хөрөнгөөр "Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем II шатны төслийг хэрэгжүүлнэ" төслийн хэрэгжилт 70%,<br>2.2022-2023 он дамжин санхүүжих авто замын түгжрэлийг бууруулах жагсаалтад орсон "Телекамер дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний удирдлагын систем Хан-Уул дүүргийн ачаалал ихтэй уулзварыг камержуулах ажил" төслийн хэрэгжилт 100%; | 80.2% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр “Цахим Улаанбаатар төсөл”-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны явцад Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан болно.<br>4.Нийслэлийн Засаг даргын захирамжаар 2023 онд захиалагчийн хяналт тавьж ажиллах эрх шилжиж ирсэн нийслэлийн төсвийн хөрөнгөөр 14, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4 төсөл, арга хэмжээ нийт 18 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 100%-12, 90%-1, 70%-1, 60%-1, 30%-2, 10%-1 төсөл арга хэмжээ хэрэгжилтийн дундаж 81.1%-ийн “тодорхой үр дүнд хүрсэн” үнэлэгдэж бөгөөд эдгээр төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцын тайлан мэдээг НЗДТГ-т албан тоотоор хүргүүлэх ажлуудын зохион байгуулан ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд тавигдах 28 төрлийн мэдээ, мэдээлэл хугацаанд нь байршуулж байгаад хяналт тавьж ажиллаж байна. | |
| 3.3 | Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг боловсруулан | - | Хөтөлбөрт хамрагдсан албан хаагчид, хувь | 15 | 21 | Албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх зорилгоор 2023 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулж, газрын даргаар баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд 2023 оны жилийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | батлуулж, хэрэгжилтийг хангуулах. | | | | | эцсийн байдлаар НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан танхимын 16 сэдэвчилсэн сургалтад давхацсан тоогоор 79 албан хаагчид дотоодын сургалт, семинарт оролцож, туршлага судалж, мэдлэгээ дээшлүүлсэн.<br>Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 5 албан хаагчид суралцаж, 4 албан хаагч нь гэрчилгээ авч, 1 албан хаагч суралцаж байна.<br>Худалдан авах ажиллагааны А3 гэрчилгээтэй сургалтад 3 албан хаагч хамрагдаж, гэрчилгээ авсан.<br>Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний хүрээнд дараахь ажлуудыг зохион байгуулсан.<br>1.Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 8 дугаар зүйлийн 8.6.5 дахь заалтад заасан дагуу 2023 онд хүүхэд төрүүлсэн 2 албан хаагчид тус бүр 300,000 төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламжийг, 1 албан хаагчид буцалтгүй мөнгөн тэтгэмжийг тус тус олгосон.<br>2.Нийслэлийн Засаг даргын даргын 2023 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох” тухай А/511 дүгээр захирамжаар шаардлагыг хангасан төрийн жинхэнэ 11 албан хаагчдад зэрэг дэвийг ахиулан болон шинээр олгосон болно. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3.Төрийн үйлчилгээний ажилтнуудын 2023 оны I-IV дүгээр улирлын ур чадварыг дүгнэн газрын даргын тушаалаар дүгнэн, 15-25% нэмэгдлийг олгож байна.<br>4.Тайлант хугацаанд газрын даргын 2 удаагийн тушаалаар нийт давхацсан тоогоор 24 албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгосон болно.<br>5.Байгууллагын батлагдсан цалингийн сандаа багтаан нийт ажилтан, албан хаагчдын унаа, хоолны мөнгийг өдрийн 9,200 төгрөг болгон нэмэгдүүлэн олгоод байна.<br>6.Ерөнхий боловсролын сургууль суралцдаг, цэцэрлэгт хүмүүждэг ажилтан, албан хаагчдын санал, хүсэлтийн дагуу байгууллагын ажлын цагийн хуваарьт Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дэх хэсгийг үндэслэн “Ажлын цагийн хуваарьт зохицуулалт”-ыг хийсэн.<br>7.Хөдөлмөрийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсгийн “Зайнаас ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ”-г боловсруулсан бөгөөд зайлшгүй зайнаас хэсэгчлэн ажиллах шаардлагатай 2 ажилтны хүсэлтийг үндэслэн газрын даргын тушаалаар хэсэгчлэн зайнаас ажиллах гэрээ байгуулан ажиллуулж байна.<br>8.Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах төлөвлөгөө, хуваарь гарган хамруулж байгаа бөгөөд нийт хамруулах 16 хүнээс 8 албан хаагчийг хамруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 9. Хөдөлмөрийн дотоод журмын 5.24-т заасны дагуу эмнэлгийн заалтаар яаралтай хагалгаанд орох болсон 1 албан хаагчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж, ажлын үр дүнгийн урамшууллыг хагас жилээр тооцож 23 албан хаагчид үндсэн цалингийн 80 хувь хүртэлх урамшууллыг тус тус олгосон. | |
| 3.4 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих. | - | Тарьсан модны тоо | 60 | 120 | МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг байгууллагын хэмжээнд дэмжин 2022 онд хуваарьт талбай болох ХУД-ийн нутаг дэвсгэрт байрлах Айцын давааны хажууд байрлах газар дээр 66 суулгацыг суулгасан бөгөөд 2023 онд дараахь арга хэмжээг зохион байгуулж оролцсон. Үүнд:<br>1.“Ногоон хот-иргэний оролцоо” хаврын мод тарих аяны хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 26-нд 2022 онд тарьсан 66 ширхэг улиас моднуудын усалгаа арчилгааг хийж шинээр 15 мод шинээр нөхөн суулгасан.<br>2.Намрын мод тарих арга хэмжээнд 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр байгууллагын хуваарьт талбайд суулгасан модны суулгацуудыг услах, нөхөн төлжүүлэх зорилгоор ХУД-ийн ЗДТГ-ын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэстэй хамтран ажилласан. | 100% |
| 3.5 | Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу | - | Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан хувь | 100% | 100% | Байгууллагын чиг үүргийн хүрээнд шүүхэд үүссэн маргаан байхгүй болно. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцах | | | | | | |
| 3.6 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах. | - | Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан хувь | 100% | 100% | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, үр дагаврын талаар мэдлэг олгох, хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сургалтад байгууллагын 14 албан хаагчдыг хамруулж, иргэдийг энэ талаарх мэдээллээр хангах, хор уршгийг иргэдэд таниулах зорилгоор “Анзаар” аяны хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээний танилцуулга, видео шторк, мэдээллийг байгууллагын цахим хуудсаар 2 удаа, фейсбүүк хуудсаар 1 удаа, нийслэлийн дотоод удирдлагын UBERP системээр 1 удаа тус тус мэдээллэж ажилласан.<br>Нийслэлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс нийслэлийн хууль, хяналтын байгууллагуудын удирдлага, хүний нөөцийн ажилтнуудад хүний эрх, хөдөлмөрлөх эрх, аюулгүй байдлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт болон Хүн бүр байгаль хамгаалагч аянд нэгдэж нэгдсэн зөвлөгөөнд тус тус 4 албан хаагчид хамрагдсан. | 100% |
| 3.7 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй | - | Байгууллагын албан хаагчдын | 50/47 | 50/50 | Байгууллагын хэмжээнд эрэгтэй албан хаагч 13, эмэгтэй албан хаагч 10 ажиллаж байгаа бөгөөд хүйсийн харьцаа 40:60 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах. | | хүйсийн харьцаа | | | байна. Жендерийн үндэсний хорооноос “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”, “Хүндлэл-хамгийн тод гэрэл” уриа болон санаачилгыг дэмжин, нийслэлийн нутгийн захиргааны 1,200 байгууллагын 29,000 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаагаа цахимаар явуулдаг Дотоод удирдлагын UBERP системийн үйл явдал хэсэгт нээлттэй байршуулсан. Мөн байгууллагын цахим хуудас https://it.ulaanbaatar.mn/ болон байгууллагын facebook хуудсаараа дамжуулан иргэд олон нийтэд нээлттэй байршуулах ажлыг зохион байгуулсан. | |
| 3.8 | Цахим засаглалыг нэвтрүүлсэн гадны орнуудын туршлагыг судлах, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулах | - | Хамтын ажиллагаа тогтоосон байгууллагын тоо | 2 | 5 | Нийслэлийн салбар бүрт цахим засаглалын төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ижил чиг үүрэг бүхий улс оронтой хамтран ажиллах, туршлага судласан. Үүнд:<br>1.БНХАУ-д “Ухаалаг хотыг байгуулах нь”, “Дэлхийн чиг хандлага дахь дижитал эдийн засаг” чиглэлийн хүрээнд 2 албан хаагч 14 хоногийн сургалтад хамрагдсан.<br>2.Япон Улсад “Нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн систем”-ийг оновчтой ашиглах өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх чиглэлд 3 албан хаагч туршлага судалсан.<br>3.Япон улсад “Мегаполис хотын сүлжээний дэд бүтэц, аюулгүй байдал” чиглэлээр 2 албан хаагч туршлага судалсан. Мөн ОХУ, АНЭ Улс орнуудаас туршлага судлан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллаж байгаа бөгөөд 2 удаагийн цахим уулзалтыг зохион байгуулж, цахим засаглалын төслүүдийн үр дүнг сайжруулах чиглэлд туршлага судалж хамтын ажиллагааг өргөжүүлсэн. | |
| 3.9 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримт бичгийг бүрдүүлэн архив бүрдүүлэх, баримт бичгийг нэр төрөл, зохион байгуулалт, он цаг, ач холбогдол зэрэг шинжүүдээр ангилан төрөлжүүлж, хэрэг бүрдүүлж буй байдалд хяналт тавих, арга зүйгээр хангах | - | Архивын нэгж бүрдүүлэлтийн хувь | 100% | 100% | Байгууллагын 2022 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын архивт баримт хүлээн авах төлөвлөгөө, хуваарийг 2023 оны 03 дугаар сарын 15 -нд газрын даргаар батлуулсан. Тус төлөвлөгөөний хүрээнд холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж байна. | 100% |
| 3.10 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний жилийн ажлын төлөвлөгөөний дагуу бодлогын болон захирамжлалын баримт бичиг, хууль тогтоомж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, хяналт тавих | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 98% | 100% | Бодлогын болон захирамжлалын баримт бичгүүд бусад төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээний 2023 онд хийх ажлын төлөвлөгөөг газрын даргаар 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу бодлогын баримт бичиг /Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө/-ийн хэрэгжилтэд явцын болон эцсийн гэсэн 2 хугацаанд хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 371 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2-т заасан аргачлыг баримтлан үнэлгээ хийж, зөвлөмж гарган нийслэлийн дотоод удирдлагын UBERP системийн Хяналт шинжилгээ үнэлгээ системд цахимаар болон албан тоотоор тайлагнаж НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст албан тоотоор хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>1. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 3 зорилтын 6 арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 76%-тай байна.<br>2. Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2 зорилтын 5 арга хэмжээний хэрэгжилт 62% байна.<br>3. Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд 2 зорилтын 5 арга хэмжээнийн хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 67,5% тай байна.<br>Дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхдээ "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3-т тусгагдсан аргачлалыг баримтлан ажилласан. Үүнд:<br>Байгууллагын хэмжээнд Засгийн газрын тогтоол 5, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 4 нийт 10 заалтын дундаж хэрэгжилт 87%-тай байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Байгууллагын хэмжээнд иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 49 өргөдөл гомдол, санал, хүсэлт ирснээс 21 гомдол, 9 санал, 17 хүсэлт, 2 зөрчлийн шийдвэрлэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажилласан бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 1 цаг байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг өмнөх жилтэй харьцуулахад /2022 оны сүүлийн хагас жилийн дундаж хугацаа 19 хоног 21 цаг 53 минут байсан/ 2023 оны 3 дугаар улирлын дундаж хугацаа 9 хоног 1 цаг 53 минут болж буурсан. | |
| 3.11 | Авлигатай тэмцэх хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн дагуу авах, тайлагнах, хяналт тавих | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Авлигын эсрэг хуулийн хүрээнд 15 албан тушаалтан 2022 оны “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын шинэчилсэн мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалт”-ын дагуу нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан тоотоор хүргүүлсэн бөгөөд хуулийн хугацаанд нь хөрөнгө орлогын шинэчилсэн мэдүүлгийг авч баталгаажуулж ажилласан. 2022 оны ХАСХОМ-ыг 15 мэдүүлэг гаргагчаас хугацаанд нь мэдүүлж, хянан, бүртгэн, баталгаажуулж, ХАСХОМ-1 тайлан, ХАСХОМ-2 тайланг тус тус НЗДТГ-т хүргүүлж ажилласан. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу шинээр албан тушаалд томилогдох болон дэвшин томилогдох 12 албан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчийн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж Хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын цахим системд хугацаанд нь мэдүүлэх ажлыг зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Мэдье, нэгдье" 1 сарын аяны хүрээнд газрын даргаар 2023.10.06-ны өдөр төлөвлөгөө батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 1 сарын хугацаанд байгууллага дээрээ хэрэгжүүлэн ажилласан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хэрэгжүүлэн тайлан, мэдээг газрын даргын 2023 оны 01/452 дугаар албан бичгийн хавсралтаар хугацаанд нь НЗДТГ-т хүргүүлэн ажилласан бөгөөд Нийслэлийн нутгийн захиргааны 90 гаруй байгууллагуудаас шалгарч 2023.12.01 өдөр "Батламж", мөнгөн шагналаар шагнагдсан болно. | |
| | **Зорилт 4. Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжилтийг хангах** | | | | | | |
| 4.1 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлдэг үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системийг хөгжүүлэх /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.1/ | - | Цахимжуулсан үйлчилгээ, хувь | 30% | 40% | Төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn систем, түүний дэд систем болох "E-Business" платформуудад Нийслэлийн "Онлайн бизнес төв" системээр үзүүлж буй бизнес эрхлэгчдэд зориулсан нутгийн захиргааны 10 байгууллагын нийт 86 үйлчилгээг холбосон. Ингэснээр 3 эх үүсвэрээр иргэн аж ахуй нэгж байгууллагаас хүсэлтийг хүлээн авдаг болсон байна. Нийслэлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нутгийн захиргааны 17 байгууллагын төрийн үйлчилгээ цахимжсан. | |
| 4.2 | Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийслэлд хэрэгжүүлж байгаа мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд хяналт тавьж ажиллах /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.2/ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн Засаг даргын захирамжаар 2023 онд захиалагчийн хяналт тавьж ажиллах эрх шилжиж ирсэн нийслэлийн төсвийн хөрөнгөөр 14, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4 төсөл, арга хэмжээ нийт 18 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 100%-12, 90%-1, 70%-1, 60%-1, 30%-2, 10%-1 төсөл арга хэмжээ хэрэгжилтийн дундаж 81,1%-ийн "тодорхой үр дүнд хүрсэн" үнэлэгдэж бөгөөд эдгээр төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцын тайлан мэдээг НЗДТГ-т албан тоотоор хүргүүлэх ажлуудын зохион байгуулан ажиллаж байна. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээд хяналт тавьж, зөвлөгөө өгч ажилласан. Үүнд:<br>1.Үндэсний их баяр наадмын хурдан морины унаач хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах хүрээнд Унаач хүүхэд, морины уяач, хурдан морьдын мэдээллийг урьдчилан бүртгэж баталгаажуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх "Бүртгэлийн цахим систем"-ийн техникийн даалгаврыг боловсруулж наадмын салбар комисст хүргүүлсэн бөгөөд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.<br>2.Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй автобусаар үйлчлүүлж буй | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зорчигчдынхоо тоо, төлбөр хураалтад нарийвчилсан дүн шинжилгээ хийх, тохиромжтой арга хэмжээг авахаар Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайка-ийн түншлэлийн хөтөлбөрийн японы техникийн хамтын ажиллагааны хүрээнд судалгааны баг, НТҮГ-тай хамтран Хэрэглэгчдэд чиглэсэн автобусны удирдлагын Ноу-хау болон Дижитал (AI, IOT) технологийг хэрэгжүүлж 2 автобусанд туршилт хийж, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж хамтран ажилласан.<br>3.Нийслэлийн нийтийн тээврийн газраас олгодог /Замын хөдөлгөөнд ачааны автомашин цагийн хязгаарлалттай зорчих, Хүүхэд тээвэрлэх автобусны, Ажилчдын автобусны/ түр зөвшөөрлүүдийг цахимаар олгох хөгжүүлэлт, нэвтрүүлэлтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |
| 4.3 | Хариуцсан програм хангамж, системийн ашиглалтыг сайжруулж системийн хөгжүүлэлт, найдвартай ажиллагааг хангах. /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.3/ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн доорх системүүдийн сервер тоног төхөөрөмжүүдийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хангах, шаардлагатай нэмэлт хөгжүүлэлт, техникийн туслалцаа дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна. Үүнд:<br>1.Нийслэлийн Мэдээ, мэдээллийн https://www.ulaanbaatar.mn/ цахим хуудас<br>2.Нийслэлийн цахим үйлчилгээний http://eservice.ulaanbaatar.mn/ систем<br><br>3.Нийслэлийн нутгийн захиргааны 1200 байгууллагын 30,000 гаруй албан хаагч | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдөр тутамдаа ашиглаж үйл ажиллагаа явуулдаг дотоод удирдлагын https://erp.ulaanbaatar.mn/ системтэй холбоотой 3,600 гаруй дуудлага, 10,9000 гаруй чатанд хариуг өгч ажилласан.<br><br>4.Тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний https://smartcar.mn/ системд Нийтийн тээврийн газраас олгодог нийслэлийн замын хөдөлгөөнд ачааны автомашин цагийн хязгаарлалттай зорчих түр зөвшөөрөл, хүүхэд тээвэрлэх автобусны түр зөвшөөрөл, ажилчдын автобусны түр зөвшөөрлийн үйлчилгээг 2023 онд хэрэглээнд нэвтрүүлж, хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр "Smartcar" төслийг хувийн хэвшилд шилжүүлж, системийн цаашдын хөгжүүлэлтийг хариуцан ажиллаж байна.<br>5.Нийслэлийн харъяа байнгын ажиллагаатай хяналт тавьдаг 4 товчоод /Баруун туруун, Налайх Тэрэлж, Түргэний гол, Эмээлт/-ын төлбөр авах цэгт цахим төлбөрийн tovchoo.ulaanbaatar.mn системд 2023 оны байдлаар Улаанбаатар хот руу нэвтэрсэн нийт тээврийн хэрэгслийн тоо 5,759,471 орон нутгийн дугаартай тээврийн хэрэгсэл төлбөр авах цэгээр нэвтэрч нэхэмжлэх үүссэн төлбөрийн дүн 984,395,000 төгрөг байна.<br>6.Архив албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн https://edoc.ulaanbaatar.mn систем<br>7."Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн https://service.ulaanbaatar.mn/ систем өдөр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тутам иргэдээс ирсэн 10-15 дуудлагыг цаг хугацаанд нь шуурхай шийдвэрлэж, 20180 гаруй иргэн аж ахуйн нэгж байгууллага тус системээс үйлчилгээ аван үйл ажиллагаа явуулж байна.<br>8.Нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон 15 байгууллагын 424 хэрэглэгчид хортой кодын эсрэг програм хангамжийг суулгаж хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна. 9.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ub.gov.mn домэйн дээр байрлах 262 цахим хуудасны нөөцлөлтийг тухай бүр хийн SSL-ийг сунган хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Smartcar.mn, ulaanbaatar.mn, ublegal.mn, smartub.mn, manaikhoroo.mn веб сайтуудын домэйны гэрээний хугацааг сунгуулан хэвийн ажиллагааг хангаж ажилласан.<br>10.Гаднаас хандалттай Ulaanbaatar.mn домэйн бүхий вэб сайтууд, вэб серверүүд дээр шинээр SSL сертификатыг худалдан авч системүүд дээр тохиргоо хийсэн. | |
| 4.4 | Нутгийн захиргааны байгууллагуудад хариуцсан чиг үүргийн хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах. /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.4/ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад чиг үүргийн хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, системүүдийн ашиглалттай холбоотой сургалтуудыг зохион байгуулан ажилласан. Үүнд:<br>1.Нийтийн тээврийн газраас олгодог /Замын хөдөлгөөнд ачааны автомашин цагийн хязгаарлалттай зорчих, Хүүхэд тээвэрлэх автобусны, Ажилчдын автобусны/ түр зөвшөөрлүүдийг системээр олгохтой холбогдуулан Нийтийн тээврийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5 алба хаагчдад системийн зааварчилгаа сургалтыг танхимаар болон цахимаар 2 удаа зохион байгуулсан.<br>2.UB ERP системийн ашиглалттай холбоотой сургалтыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын 35 хүний нөөцийн мэргэжилтэн, Нийслэлийн Нийгмийн даатгал болон 9 дүүргийн даатгалын 26 албан хаагчид, Нийслэлийн татвар болон 9 дүүргийн татварын хэлтсийн албан хаагчид, НБИХГ-ын 25 албан хаагч нийт 194 албан хаагчдад цахимаар сургалтуудыг зохион байгуулсан.<br>3.ННЗБ-уудын хоорондоо мэдээлэл солилцох, мэдээллийн урсгалыг сайжруулах “Сити дашбоард”-ын ашиглалтын сургалтыг нийслэлийн 6 байгууллагын 16 албан хаагчдад зохион байгуулсан.<br>Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/524 дүгээр захирамжийн хүрээнд “Улаанбааатар марафон-2023” олон улсын гүйлтийг зохион байгуулах, автоматжуулахад шаардлагатай техник технологи, системийн шийдлээр хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.<br>Төрийн албаны зөвлөлийн 2023 оны I-IV улирлын Төрийн албаны ерөнхий шалгалт зохион байгуулах бэлтгэл ажил хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан ба иргэний шалгалт өгөх боломжийг хангаж компьютер, интернэт, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сүлжээ, анги танхимыг бэлдэж шалгалтын бэлэн байдлыг ханган ажилласан.<br>Нийслэлийн хэмжээнд “Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ” RFID tag”-г иргэдийн авто машинуудад суурилуулах бэлтгэл ажлын хүрээнд тус төслийн гүйцэтгэгчээр шалгарсан компанитай хамтран Авто тээврийн үндэсний төвийн салбар нэгжүүдийн 129 ахлах ажилтнуудад программын сургалтыг зохион байгуулсан.<br>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад мэргэжил арга зүйн Дэмжлэг үзүүлэх журмын хүрээнд байгууллагын 11330844 утас болон support@ulaanbaatar.mn цахим шуудангаар ирсэн нийслэлийн байгууллагуудын сервер, дотоод сүлжээ, тоног төхөөрөмж болон интернет үйлчилгээний доголдол, цахим шуудан шинээр нээлгэх, цахим шуудангийн нууц үг сэргээх, домэйний шинэ хэрэглэгч үүсгэх, нууц үг сэргээх зэрэг нийт 234 дуудлагыг утсаар 152, албаны цахим хуудсаар 82 дуудлага ирсний бүртгэлжүүлж тухай бүр нь шуурхай шийдвэрлэж ажилласан.<br>Дүүргүүдийн мэдээллийн технологи хариуцсан 15 мэргэжилтэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дүүргийн серверийн өрөөний аюулгүй байдал болон сүлжээгээр дамжуулан хүргэж буй үйлчилгээнүүдийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.5 | Нийслэийн нутгийн захиргааны байгууллагуудад мэдээллийн их өгөгдөл үүсгэх, боломжит өгөгдлүүдийг иргэд, олон нийтэд нээлттэй болгох, их өгөгдлийг боловсруулах, дүн шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх /НЦХМТГ-ын дүрэм 4.1.5/ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | "Нийслэлийн 2023 төсөвт өөрчлөлт оруулах тухай" Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан ч байгууллагын дотоод нөөц боломжид тулгуурлан системийн модуль тус бүрийн хөгжүүлэлтийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 90% |
| 4.6 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын интернет болон харилцаа холбооны зардлыг хэмнэх санал боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах /НЦХМТГ-ын дүрэм 4.1.6/ | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100% | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1-т тусгагдсан "Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй чирэгдэлгүй хүргэх ухаалаг хотыг бий болгох" зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн анхан шатны нэгж болох хороодын хэсгийн ахлагчдын үйл ажиллагааг цахимжуулах "Хэсгийн ахлагчийн систем"-ийг 2023 оны 1-р улиралд хэрэглээнд нэвтрүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2023 оны захирамжаар "Хэсгийн ахлагчийн систем" ашиглалтын болон холбогдох бусад зардлыг дүүргийнхээ жил бүрийн төсвийн урсгал зардалд тусгаж байхыг дүүргүүдийн засаг дарга нарт үүрэг болгосон. Үүний дагуу Юнител ХХК-тай хамтран хэсгийн ахлагч бүрд юнителийн дата симтэй дугаарыг олгож, жилд 1 удаа дүүргийн урсгал зардлаас сунгуулснаар цаашид хэсгийн ахлагчийн аппликэйшныг ашиглах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүрд дата ашиглах шаардлагагүй системийн хөгжүүлэлтийг Юнител ХХК-тай хамтран зохион байгуулж ажилласан. | |
| 4.7 | Төрийн болон албаны нууц, хувь хүний нууцтай холбоотой төлбөртэй болон төлбөргүй мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу дамжуулах, байршуулах, хадгалах. /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.7/ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 2428 албаны и-мэйл хаягийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна.<br>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон албан хаагчдын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн болон албаны нууцыг хадгалах, албан хэрэглээний компьютер болон дагалдах тоног төхөөрөмжүүдийг гадна дотны халдлагаас хамгаалах, нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангах зорилгоор Нийслэлийн нутгийн захиргааны 36 байгууллагын 1278 албан хаагчдын компьютерийг нийслэлийн нэгдсэн домэйн сүлжээнд холбон хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд тавигдах 28 төрлийн мэдээ, мэдээллийг хугацаанд нь байршуулсан.<br>Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам” болон холбогдох журмын хүрээнд “Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт”, “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”, “Албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг тус тус баталж, төрийн нууцтай холбоотой ажлын баримт бичгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавьж ажиллаж байна. | |
| 4.8 | Нэгдсэн шилэн кабель, гадаад, дотоод сүлжээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хяналт тавих, сүлжээний хэвийн ажиллагааг хангах, ашиглалт үйлчилгээг хариуцах /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.8/ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн гадаад, дотоод сүлжээг зохион байгуулж нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбон ажилласан. Үүнд:<br>1.Нийслэлийн Дата төвийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цахим халдлагаас хамгаалах тоног төхөөрөмжий програм хангамжийн лицензийг сунгасан.<br>2.Нийслэлийн шалган нэвтрүүлэх товчоодын гэмтэлтэй шилэн кабелыг яаралтай засварлаж, хэвийн ажиллагаанд оруулсан.<br>3.Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шилэн кабелын гэмтэлтэй хороодыг яаралтай засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан.<br>4.Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газрууд ЧДЗДТГ-ын байр руу, шилжин нүүсэнтэй холбогдуулан компьютер тоног төхөөрөмжүүдийг сүлжээнд холбох ажлыг зохион байгуулсан;<br>2.ЦЕГ-ын Экологийн Цагдаагийн албанаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Гүнт, Өлзийт, Эмээлт, Баруунтурууны шалган нэвтрүүлэх товчоод дээр хяналтын пост | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулахад шаардлагатай сүлжээний урсгалыг гарган өгч мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан;<br>3. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Оргил салбарыг Сэлбэ бизнес инкубатор төв рүү нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн Оргил салбараас Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв (Сэлбэ бизнес инкубатор төв) хүртэл 2 км шилэн кабелын сүлжээг шинээр татаж дотоод сүлжээг зохион байгуулж нэгдсэн сүлжээнд холбох;<br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12/36 дугаар тогтоолын хүрээнд Баянзүрх, Баянгол, Хан-Уул дүүргийн шинээр байгуулагдсан хороодыг нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбосон.<br>Нийслэлийн харьяа байгууллагуудын интернетийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах зорилгоор "Комтел ХХК-"-тай интернетийн үйлчилгээ авах тухай гэрээг нийслэлийн 33 харьяа байгууллагатай гурвалсан гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.<br>Нийслэлийн гадаад, дотоод сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, ашиглалт, үйлчилгээг хариуцах хүрээнд Баянзүрх дүүргийн шилэн кабелын урсгал засварын ажлыг гүйцэтгэж сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаан ажилласан. | |
| 4.9 | Нутгийн захиргааны байгууллагуудын компьютер, техник хангамжийн найдвартай үйл | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдал, сүлжээ серверийн тоног төхөөрөмж, систем болон дэд бүтцийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулах. /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.9/ | | | | | хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна. Үүнд:<br>● Интернет үйлчилгээг 33 байгууллагад;<br>● ННЗ-ны 47 байгууллага, 9 дүүргийн ЗДТГ болон 204 хороонд;<br>● Цагдаагийн дотоод сүлжээг 131 хороонд;<br>● Утасгүй интернетийг 151 байршилд;<br>● ОӨУБЕГ-ийн дотоод сүлжээг 166 хороонд;<br>● Төрийн сангийн дотоод сүлжээг 6 дүүрэгт;<br>● Нийслэлийн Газрын албаны дотоод сүлжээг 6 дүүрэгт;<br>● ННЗБ-ын 278 цахим хуудас<br>● ulaanbaatar.mn болон ub.gov.mn, citycouncil.mn, ublegal.mn, smartcar.mn зэрэг томоохон системүүдийг;<br>● ННЗБ-ын мэдээллийн аюулгүй байдал;<br>● Нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн сан;<br>● Нийслэлийн Газрын албаны сервер, тоног төхөөрөмж;<br>● Нийслэлийн Архивын газрын сервер, тоног төхөөрөмж;<br>● Нийслэлийн Шуурхай удирдлага зохицуулалтын төвийн сервер, тоног төхөөрөмж;<br>● Нийслэлийн Нийтийн Тээврийн газрын сервер, тоног төхөөрөмж;<br>● Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын сервер, тоног төхөөрөмж; | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Нийслэлийн Бодлогын судалгааны шинжилгээний төвийн сервер, тоног төхөөрөмж;<br>• Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын сервер, тоног төхөөрөмж;<br>• ННЗБ-ын физик 88, виртуал 176 сервер;<br>• ННЗБ-ын 130 систем;<br>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын сервер, дотоод сүлжээ, тоног төхөөрөмж болон интернет үйлчилгээний доголдол, цахим шуудан шинээр нээлгэх, мөн цахим шуудангийн нууц үг сэргээх, домэйний шинэ хэрэглэгч үүсгэх, нууц үг сэргээх нийт 234 дуудлагуудыг хүлээн авснаас утсаар 152 дуудлага, албаны цахим хуудсаар 82 дуудлагыг хүлээн авч “Дэмжлэг үзүүлэх төвийн үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу тухай бүр шуурхай шийдвэрлэж ажилласан.<br>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас ашиглалтын хугацаа дууссаны улмаас ашиглах боломжгүй болсон 11 төрлийн 23 тоног төхөөрөмжийн нөхцөл байдлыг тодорхойлж мэргэжлийн дүгнэлт гаргасан. | |
| 4.10 | Нийслэлийн нэгдсэн дата төвийн сервер, тоног төхөөрөмжүүдийн мэдээллийн аюулгүй байдал, хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ, тохиргоо, | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн нэгдсэн дата төвийн сервер, тоног төхөөрөмжүүдийн мэдээллийн аюулгүй байдал, хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ, тохиргоо, угсралт суурилуулалтыг хийн ажилласан. Үүнд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | угсралт суурилуулалтыг хариуцан ажиллах. /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.10/ | | | | | 1.Нийслэлийн Дата төвийн дараахь тоног төхөөрөмж болон програм хангамжийн лицензийг сунгасан. Үүнд:<br>• Сүлжээний хамгаалалтын fortigate дараа үеийн галт хана төхөөрөмжийн халдлага эсэргүүцэх, илрүүлэх модулын лиценз;<br>• Barracuda веб системийн галт хана төхөөрөмжийн халдлага эсэргүүцэх лиценз;<br>• Cisco ASA галт хана төхөөрөмжийн халдлага эсэргүүцэх лиценз;<br>2.Дата төвийн халаалт, салхивч, агааржуулагчийн систем болон сүлжээний үндсэн төхөөрөмжүүдэд 2 удаагийн төлөвлөгөөт үзлэг шалгалтыг зохион байгуулж, хэвийн найдвартай ажиллагааг ханган ажилласан.<br>3."Нийслэлийн дата төвийн физик аюулгүй байдлыг хангах хүрээнд дараахь ажлуудыг зохион байгуулсан.<br>• Кибер аюулгүй байдлын удирдлага зохион байгуулалтын нөхцөл байдлыг тодорхойлох<br>• Кибер аюулгүй байдлыг хангах дотоод журмуудыг шинэчлэн боловсруулах<br>• Мэдээллийн системд нэвтрэх туршилт хийх, нууцгмал эрсдэлүүдийг олж тогтоон бууруулах аргачлал боловсруулах<br>• Кибер юулгүй байдлын мэдээллийн сүлжээний аюулгүй байдлын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналтууд бий болгож нэвтрүүлэх ажлуудыг зохион байгуулж байна.<br>4.Орон зайн дундын мэдээллийн системийг аппликейшн өгөгдлийн сан, зураглалаар гэж 3 хувааж мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.<br>5.Олон нийтийн санал дэвшүүлэх vote.ulaanbaatar.mn системийг 3 зохиомол сервер үүсгэн зохион байгуулсан.<br>6.Зам тээврийн нэгдсэн системийн аюулгүй байдлын 5 системийн хувилбарыг сайжруулсан.<br>7. Сар бүр Linux серверүүдийн security болон kernel update-үүдийг хийсэн.<br>8. Сар бүр Windows OS -тэй server үүд дээр сарын cumulative update-үүд хийсэн.<br>Тагнуулын ерөнхий газраас нийслэлийн Дата төвийн кибер аюулгүй байдлын эрсдэлийн түвшинг тогтоох үнэлгээг хийсэн бөгөөд Мэдээллийн аюулгүй байдлын газраас өгсөн зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох ажлуудыг зохион байгуулан ажилласан.<br>Нийслэлийн Дата төвд ашиглагдаж байгаа windows болон linux серверүүдийн security update фачуудыг суулгасан cpanel серверийн OS хуучирч support байхгүй болсон мөн cpanel update хийгдэхгүй болсонтой холбогдуулан шинээр VPS server үүсгэж Almalinux9 суулгаж Cpanel суулгаж тохируулан одоо байгаа серверээс migration хийж, бүх датаг хуулж оруулан тест хийж байгаа, мөн шинээр үүсгэж ашиглаж байгаа vmware Vcenter серверийн шинэчлэлт update гарч 8.0.1 – | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ээс 8.0.2.00100 хувилбараар шинэчлэлт хийсэн.<br>Нийслэлийн Дата төвд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 18 зохиомол сервер үүсгэсэн байна. | |
| 4.11 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын телехяналтын камеруудын техникийн даалгавар боловсруулах, бүртгэлжүүлэх. /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.11/ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн хэмжээнд 2023 онд Улсын төсөв болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн хөрөнгө, дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх нийслэлийн БЗД, СБД, ХУД, СХД, БГД-ийн дүүргүүдийн **609** цэгийн **1586** камерын **28** техникийн даалгаврыг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд дээрх камеруудыг “Зам, тээврийн нэгдсэн систем”-ийн камерын хяналтын системд холбохоор ажиллаж байна. | 100% |
| 4.12 | Теле хяналтын систем, хяналтын камер, шилэн кабел, гадаад, дотоод сүлжээ, сервер, систем болон тоног төхөөрөмжийн техникийн даалгавар боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах, хяналт тавих. /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.12/ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | НЗД-ын 2019 оны А/755 дугаар захирамжийн хүрээнд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт шинээр суурилуулахаар төлөвлөж буй хяналтын камеруудыг техникийн даалгаварын дагуу хүлээн авч, телехяналтын камерын нэгдсэн системд холбон ажилласан. Үүнд:<br>1. “Баянзүрх дүүргийн 23, 28 дугаар хорооны 35 цэгийн 72 камер;<br>2. “Төвийн 6 дүүргийн автобусны буудлын камержуулалтын чиглэлээр 103 цэгийн 197 камер;<br>“Улаанбаатар хотын телехяналтын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам”-ын хүрээнд ХУД-ын 1-11, 14-21, 4-14, 16, 21, БГД-ийн 16, 23, ЧД-ийн 6, СБД-ийн 9 дүгээр хороодын гадна суурилагдах камержуулалтын ажлын гадна холбооны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зураг төсөлд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. | |
| 4.13 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон дүрэм, журмуудыг мөрдөж ажиллахад хяналт тавих, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах. /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.13/ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллага дотооддоо Мэдээллийн аюулгүй байдлын журам боловсруулан мөрдөн ажиллаж байна. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон албан хаагчдын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, албан хэрэглээний компьютер болон дагалдах тоног төхөөрөмжүүдийг гадна дотны халдлагаас хамгаалах, нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангах зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны 47 байгууллагын сүлжээ, дата төвийн 88 физик сервер, виртуал 176 сервер, хадгалах төхөөрөмж, 130 системийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангаж, 1278 хэрэглэгчийг нэгдсэн домэйнд холбон хэвийн ажиллагааг ханган ажилласан. Байгууллагын сүлжээний аюулгүй байдлын хүрээнд Засгийн газрын 2018 оны “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2018 оны “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” А/509 дүгээр захирамжийн дагуу нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон байгууллагуудын сошиал суваг (Facebook, Twitter, Youtube, Instgram, Steam гэх мэт)-ыг нэгдсэн байдлаар хаах ажлыг зохион байгуулсан. Нийслэлийн төр захиргааны болон харьяа байгууллагуудтай байгуулсан гэрээг шинэчлэх, сунгах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлуудыг зохион байгуулж, техник тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг хангуулан ажиллаж байна. | |
| 4.14 | Нийслэлийн хэмжээнд “Цахим тоглоомын төв”-ийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.14/ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50% | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн тогтоолоор “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам” батлагдаж, энэ журмын 6.3. дахь заалтад журмын 2.7.1-д заасан үйлчилгээг (Цахим тоглоомын үйлчилгээний хүсэлт) нийслэлийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан газар хүлээн авч хянан баталгаажуулна гэсний дагуу үйлчилгээ эрхлэх бүртгэлийг баталгаажуулахаар холбогдох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт 2021 оны 03 дугаар сарын 10-ны байдлаар авсан тоон мэдээгээр 375 гаруй цахим тоглоомын үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Онлайн бизнес төвийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-ээр 47 хүсэлт ирсэн. Цаашид бүртгэж явахад системийн хувьд хөгжүүлэлт хийгдсэн бөгөөд бусад мэргэжлийн байгууллагуудын саналыг үндэслэн цахим тоглоомын газрын тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэхээр холбогдох албан хүсэлтүүдийг хүргүүлэх ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. | 100% |
| 4.15 | Иргэд, төрийн байгууллагын хэрэгцээ, шаардлагад | - | Үйл ажиллагааны | 70% | 100% | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад цахим шилжилт буюу | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тулгуурлан нийслэлийн цахим шилжилтийн ажлыг оновчтой төлөвлөн зохион байгуулах, оролцогч талуудын уялдаа холбоог хангах /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.15/ | | хэрэгжилтийн хувь | | | төрийн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, нээлттэй, хүнд сурталгүй хүргэх, засаглалыг сайжруулах чиглэлээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх "Цахим Улаанбаатар" төслийн хүрээнд дараахь нийгмийн томоохон салбаруудад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.<br>• Боловсролын салбар<br>• Төрийн үйлчилгээний салбар<br>• Эрүүл мэндийн салбар<br>• Зам, тээврийн салбар<br>• Төрийн байгууллагын хяналт, үйл ажиллагаа<br><br>Дээрх чиглэлд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах эрхийг нийслэлийн Засаг даргын 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/1202 дугаар захирамжаар баталсан бөгөөд 7 төсөл, арга хэмжээний техникийн даалгаврыг боловсруулж нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн боловч "Нийслэлийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан болно. Төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn систем, түүний дэд систем болох "E-Business" платформуудад Нийслэлийн "Онлайн бизнес төв" системээр үзүүлж буй бизнес эрхлэгчдэд зориулсан нутгийн захиргааны 10 байгууллагын нийт 86 үйлчилгээг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбосон. Ингэснээр 3 эх үүсвэрээр иргэн аж ахуй нэгж байгууллагаас хүсэлтийг хүлээн авдаг болсон. | |
| 4.16 | Цахим шилжилтийг амжилттай нэвтрүүлсэн гадаадын хот, байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох, туршлага судлах, эрх бүхий байгууллагад санал уламжлан шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.16/ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 70% | 100% | Нийслэлийн салбар бүрт цахим засаглалын төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх хүрээнд БНХАУ, БНСУ, Сингапур улсын мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ижил чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчидтай 2 удаагийн цахим уулзалтыг зохион байгуулж, 3 албан хаагч БНХАУ, Япон улсад сургалт, туршлага судлах арга хэмжээнд оролцож цахим засаглалын төслүүдийн үр дүнг сайжруулах чиглэлд туршлага судалсан. 1.БНХАУ-д “Ухаалаг хотыг байгуулах нь”, “Дэлхийн чиг хандлага дахь дижитал эдийн засаг” чиглэлийн хүрээнд 2 албан хаагч<br>2.Япон Улсад “Нийтийн тээврийн төлбөрийн систем”-ийг оновчтой ашиглах өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх чиглэлд 3 албан хаагч<br>3.Япон улсад “Мегаполис хотын сүлжээний дэд бүтэц, аюулгүй байдал” чиглэлээр 2 албан хаагч туршлага судалсан. Мөн ОХУ, АНЭ Улс орнуудаас туршлага судлан ажиллаж байгаа бөгөөд 2 удаагийн цахим уулзалтыг зохион байгуулж, цахим засаглалын төслүүдийн үр дүнг сайжруулах чиглэлд туршлага судалсан. | 100% |
| 4.17 | Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн чиг үүргийн хүрээний асуудлаар төслийн санал | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад цахим шилжилт буюу төрийн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг хангаж, хяналт тавих. /НЦХМТГ-ийн дүрэм 4.1.17/ | | | | | ил тод, нээлттэй, хүнд сурталгүй хүргэх, засаглалыг сайжруулах чиглэлээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх “Цахим Улаанбаатар” төслийг боловсруулан холбогдох тооцоо судалгааг гарган НЗДТГ-т хүргүүлж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 115 дугаар тогтоолоор баталсан. “Цахим Улаанбаатар” төслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг нийслэлийн Засаг даргын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/1202 дугаар захирамжаар баталсан бөгөөд 7 төсөл, арга хэмжээний техникийн даалгаврыг боловсруулж нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн болович “Нийслэлийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсөв татагдсан болно. | |
| 4.18 | Телекамер дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний удирдлагын систем /Улаанбаатар хот/ | 540.0 | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 30% | 50% | Нийслэлийн 2023 төсвийн хөрөнгөөр 2023 онд Хан-Уул дүүргийн ачаалал ихтэй уулзвар /120 мянгат, нарантуул зах/, дээр 2 чиглэлийн урсгал дээр улсын дугаар таних тусгай зориулалтын LPR 10 камер болон гэрэлтүүлэг 10 Infra гэрэл суурилуулж замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг илрүүлэх хяналтын камераар бүрэн тоноглосон бөгөөд холбогдох техник, тоног, төхөөрөмж болон бүртгэл зөрчил, дундаж хурдыг хэмжих системийг хөгжүүлж хүлээлгэн өгсөн. | 100% |
| 4.19 | Нийслэлийн Засаг даргын захирамжаар эрх шилжсэн төсөл арга хэмжээнүүдэд | - | Захиалагчийн хяналт тавьж ажилласан | - | 100% | Нийслэлийн Засаг даргын 2022, 2023 оны 5 захирамжаар эрх шилжсэн 10 төслүүдэд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | захиалагчийн хяналт тавьж ажиллах.<br>/1.Авто тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээ (RFID tag)-г суурилуулах<br>2.Өлзийтийн зам, Архивын ерөнхий газрын зүүн талд тээврийн хэрэгслийн зөрчил илрүүлэх камер суурилуулах (урдаас хойш, хойноос урагш 2 чиглэлд хянах)<br>3.Сонсголонгийн замд тээврийн хэрэгслийн зөрчил илрүүлэх камер суурилуулах (урдаас хойш, хойноос урагш 2 чиглэлд хянах)<br>4.Саппорогийн уулзалт 4 чиглэлд хяналтын камер, 2 чиглэлд тээврийн хэрэгслийн зөрчил илрүүлэх камер суурилуулах<br>5.Чингэлтэйн өргөн чөлөө, 32-ын уулзварт 4 чиглэлд тээврийн хэрэгслийн зөрчил илрүүлэх камер суурилуулах<br>6.Замын хөдөлгөөний удирдлагын төв дээр мэдээлэл хадгалах, боловсруулах сервер, програм хангамж, тоног төхөөрөмж суурилуулах | | төслийн хэрэгжилт | | | захиалагчийн хяналт тавьж ажилласан. Үүнд:<br>1.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 207 дугаар захирамж: Автотээврийн үндэсний төвийн техникийн хяналтын үзлэгийн 7 төв, хувийн хэвшлийн 9 төвөөр дамжуулан 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 75,722 тээврийн хэрэгсэлд суурилуулаад байна.<br>2.Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1313 захирамжийн хүрээнд дараахь төслүүдэд захиалагчийн хяналт тавьж байна. Үүнд:<br>- НЦХМТГ/2023-05-01 Өлзийтийн зам, Архивын ерөнхий газрын зүүн талд тээврийн хэрэгслийн зөрчил илрүүлэх камер суурилуулах (урдаас хойш, хойноос урагш 2 чиглэлд хянах) ажлын тоног төхөөрөмж угсарч суурилуулсан;<br>- НЦХМТГ/2023-05-02 Сонсголонгийн замд тээврийн хэрэгслийн зөрчил илрүүлэх камер суурилуулах (урдаас хойш, хойноос урагш 2 чиглэлд хянах) ажлын тоног төхөөрөмж угсарч суурилуулсан;<br>- НЦХМТГ/2023-05-03 Саппорогийн уулзварт 4 чиглэлд хяналтын камер, 2 чиглэлд тээврийн хэрэгслийн зөрчил илрүүлэх камер суурилуулах ажлын тоног төхөөрөмж угсарч суурилуулсан;<br>- НЦХМТГ/2023-05-04 Чингэлтэйн өргөн чөлөө, 32-ын уулзварт 4 чиглэлд тээврийн хэрэгслийн зөрчил илрүүлэх камер суурилуулсан;<br>-НЦХМТГ/2023-05-05 Замын хөдөлгөөний удирдлагын төв дээр мэдээлэл хадгалах, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 7.Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Удирдлагын төвийн серверийн өрөөний техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх<br>8.Автобусны буудлын хяналтын цэг байгуулах (103 буудал)<br>9.Автобусны буудлын хяналтын цэгийг Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Удирдлагын төвтэй холбох сүлжээ, дэд бүтцийн ажил<br>10.УС-15 хотхоны камержуулалт (БЗД, 8 дугаар хороо) | | | | | боловсруулах сервер, программ хангамж, тоног төхөөрөмж суурилуулсан;<br>Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1369 захирамжийн хүрээнд дараахь төслүүдэд захиалагчийн хяналт тавьж байна.<br>- НЦХМТГ/2022-30 Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Удирдлагын төвийн серверийн өрөөний техникийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн;<br>- НЦХМТГ/2022-30 Автобусны буудлын хяналтын цэг байгуулах (103 буудал) аас 100 цэгт тоног төхөөрөмжийн суурилуулалсан;<br>- НЦХМТГ/2022-30 Автобусны буудлын хяналтын цэгийг Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Удирдлагын төвтэй холбох сүлжээ, дэд бүтцийн ажлуудыг тус тус 100% гүйцэтгэлтэй дуусгасан.<br>Нийслэлийн засаг даргын 2022 оны А/506 захирамжийн хүрээнд дараахь төсөлд захиалагчийн хяналт тавьж ажиллаж байна. Үүнд:<br>- НХААГ/202212052 Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны УС-15 хотхоны камержуулах ажлыг 100% хүлээн авсан. | |
| 4.20 | Хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлдэг үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, үзүүлэлт, шаардлагыг тодорхойлох үндэсний болон хотын стандартын төсөл боловсруулах, хүчин төгөлдөр мөрдөгдөж стандартын баримт бичгийг | - | Стандартын баримт бичгийг мөрдөж ажилласан хувь | 100% | 100% | Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт шинээр суурилуулахаар төлөвлөж буй хяналтын камеруудыг техникийн шийдлийг гаргах, хүлээн авах, телехяналтын камерын нэгдсэн системд холбох чиг үүргийн хүрээнд Нийслэлийн хэмжээнд 2023 онд Улсын төсөв болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн хөрөнгө, дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх нийслэлийн БЗД, СБД, ХУД, СХД, БГД-ийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мөрдүүлэх, хяналт тавих, сурталчилан таниулах | | | | | дүүргүүдийн 609 цэгийн 1586 камерын 28 техникийн даалгаврыг МУ-ын стандарт “Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага MNS 6423:2019” болон “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, ерөнхий шаардлага MNS 6423:2013”-уудын боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, гүйцэтгэлийг хүлээн авах бүртгэлжүүлэх ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 18-26 дугаар тогтоолоор нийслэлийн ирэдийн эрүүл аюулгүй амьдрах эрхийг хангахад чиглэсэн 9 бүлгийн 38 хотын стандарт хүчингүй болсон. | |
| 4.21 | Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг сайжруулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль шинээр батлагдсантай холбоотой байгууллагын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалган тогтоох, төрийн албан хаагчийн ёс зүйн сахилга хариуцлагын чиглэлээр сургалт зохион явуулах үүрэг бүхий "Ёс зүйн дэд хороо"-ны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын 21 албан хаагчидтай "Хариуцлагын гэрээ" байгуулж, "Ёс зүйн мэдэгдэл"-ийг баталгаажуулж авсан. Байгууллагын албан хаагчдын Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах хүрээнд албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ажилдаа ирэх, ажлаас тарах цагийг хурууны хээгээр цаг бүртгэлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | системд уншуулж, бүртгэлийн дүнг цалин хөлстэй уялдуулан тооцож байна. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд хоцорсон, ажлын цаг ашиглалтыг баримтлаагүй албан хаагчдын цалингаас тооцож суутгах заалтыг нэмэлтээр тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Ажлын зайлшгүй шаардлагаар бусад байгууллагад ажиллах, сургалт, уулзалт зөвлөгөөнд оролцох, яаралтай бичиг баримт хүргүүлэх зэрэг тохиолдолд гадуур ажлын дэвтэр хөтлөн, бүртгэлийг тогтмолжуулсан. | |
| 4.22 | Байгууллагын архивын баримт бүрдүүлэлтийг сайжруулах, баримт бичгийн нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг идэвхижүүлэх | | Архивын дүрэм журмын хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Байгууллагын 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг ББНШК-ын хурлаар хэлэлцэн эцэслэж, Нийслэлийн архивын газраас баталгаажуулах ажил хүлээгдэж байна. Байгууллагын архивын баримт бүрдүүлэлтийн хувьд 4 хэлтсээс 2022 оны архивын баримт, материалыг үдээгүй задгайгаар нь хүлээн авсан байсныг байнгын болон түр хадгалах баримтаар нь дахин ангилалт хийж хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу үдэж хавтаслуулахаар бэлтгэж байна. | 100% |
| **Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах** | | | | | | | |
| 5.1 | Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулах. | - | Нээлттэй байршуулсан мэдээллийн тоо | 35 | 15 | Мэдээллийн технологийн чиглэлээр нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд судалгаа шинжилгээ хийгдээгүй бөгөөд 2022 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудын үр дүнг байгууллагын цахим хуудаст байршуулж иргэд олон нийтэд нээлттэй мэдээллэж ажиллаж байна. Нийтийн мэдээллийн ил | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллүүдийн 98 шалгуур үзүүлэлтүүдээс байгууллагын чиг үүрэг үйл ажиллагаатай хамааралтай 65 шалгуурын дагуу нээлттэй мэдээллүүдийг цахим хуудастаа байршуулж холбогдох тайлан мэдээг НЗДТГ-т хүргүүлэн ажилласан болно. | 100% |
| 5.2 | “Цахим улаанбаатар” төсөл, “Digital first” аяны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, цахим хөгжлийн багц хуулийг сурталчлан таниулах, хуульд заасны дагуу нээлттэй өгөгдөл, мэдээлэл, нийтийн мэдээллийн сангийн хэрэгжилтийг хангуулах | - | Хууль тогтоомжийг сурталчилан танилиулах арга хэмжээ зохион байгуулсан тоо | - | 5 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад цахим шилжилт буюу төрийн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, нээлттэй, хүнд сурталгүй хүргэх, засаглалыг сайжруулах чиглэлээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх “Цахим Улаанбаатар” төслийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл болон Зам, тээврийн нэгдсэн систем” төслүүдийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын "ICT Expo" 2023 арга хэмжээн дээр иргэд олон нийтэд танилцуулсан. Нийслэлийн 2023 оны төсөвт тусгагдсан “Цахим Улаанбаатар” төсөл”-ийн техникийн даалгаврыг боловсруулан нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн боловч “Нийслэлийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор төсвийг эргүүлэн татсан тул хэрэгжих боломжгүй болсон. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллүүдийн 98 шалгуур үзүүлэлтүүдээс байгууллагын чиг үүрэг үйл ажиллагаатай хамааралтай 65 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгуурын дагуу нээлттэй мэдээллүүдийг цахим хуудастаа байршуулж холбогдох тайлан мэдээг НЗДТГ-т хүргүүлэн ажилласан болно.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу "Үндсэн систем /ХУР/-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ" болон "Танилт нэвтрэлтийн /ДАН/ систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулж байгууллага хооронд нээлттэй өгөгдөл, сервис дамжуулах боломжийг бүрдүүлсэн.<br>Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын хүрээнд "Нээлттэй мэдээллийн жагсаалт"-д тусгах саналаа боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | |
| 5.3 | Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар нийслэлийн хороодын хэсгийн ахлагчийн системээр дамжуулан ирүүлсэн зөрчлийн мэдээллийг өдөрт нь багтаан хүлээн авч ажлын 5 | - | Зөрчил шийдвэрлэлтийн хувь | - | 100% | Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүрэг болон үйл ажиллагааны хүрээнд 2023 онд "Хэсгийн ахлагчийн систем"-ээр ирсэн зөрчил бүртгэгдээгүй болно. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хоногийн дотор шийдвэрлэх ажлыг зохион байгуулах. | | | | | | |
| 5.4 | Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах. | - | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн хувь | 30% | 50% | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад цахим шилжилт буюу төрийн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, нээлттэй, хүнд сурталгүй хүргэх, засаглалыг сайжруулах чиглэлээр дараахь ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд: Төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn систем, түүний дэд систем болох "E-Business" платформуудад Нийслэлийн “Онлайн бизнес төв” системээр үзүүлж буй бизнес эрхлэгчдэд зориулсан нутгийн захиргааны 10 байгууллагын нийт 86 үйлчилгээг холбосон. Ингэснээр 3 эх үүсвэрээр иргэн аж ахуй нэгж байгууллагаас хүсэлтийг хүлээн авдаг болсон байна. Байгууллагын дүрмээр тусгагдсан үндсэн чиг үүргийн хүрээнд иргэн аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үйлчилгээ үзүүлдэггүй бөгөөд иргэн аж ахуйн нэгж байгуулагаас өргөдөл гомдол хүлээн авах эх үүсврийг нэмэгдүүлж ажилласан. Байгууллагын хэмжээнд 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн нийт 49 өргөдөл гомдол, санал, хүсэлт ирснээс Засгийн газрын 11-11 төвийн дугаараас **28**, eservice.mn системээр **4**, 1800-1200 тусгай дугаараас **9**, НҮНТ-өөр **2**, онлайн бизнес төв системээр **1**, хэсгийн ахлагчийн системээр **3** өргөдөл, гомдол, хүсэлтийг **6** эх үүсвэрээр хүлээн авч шийдвэрлэж ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллүүдийн 98 шалгуур үзүүлэлтүүдээс байгууллагын чиг үүрэг үйл ажиллагаатай холбоотой 65 шалгуурын дагуу нээлттэй мэдээллүүдийг цахим хуудастаа байршуулж холбогдох тайлан мэдээг НЗДТГ-т хүргүүлэн ажилласан болно. | |
| 5.5 | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | Өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн хугацаа, хоног | 4 | 3 | Байгууллагын хэмжээнд иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар нийт 49 өргөдөл гомдол, санал, хүсэлт ирснээс 21 гомдол, 9 санал, 17 хүсэлт, 2 зөрчлийн шийдвэрлэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажилласан бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 1 цаг байна. Өргөдөл, гомдлыг эх үүсвэрээр нь ангилвал Засгийн газрын 11-11 төвийн дугаараас 28, eservice.mn системээр 4, 1800-1200 тусгай дугаараас 9, НҮНТ-өөр 2, онлайн бизнес төв системээр 1, хэсгийн ахлагчийн системээр 3 өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж ажилласан. Иргэд аж ахуйн нэгж байгууллагас ирсэн нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг өмнөх жилтэй харьцуулахад /2022 оны сүүлийн хагас жилийн дундаж хугацаа 19 хоног 21 цаг 53 минут байсан/ 2023 оны 3 дугаар улирлын дундаж хугацаа 9 хоног 1 цаг 53 минут болж буурсан бөгөөд шийдвэрлэлтийн хугацааг 1 орон тоонд оруулсан үзүүлэлттэй байна. Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн нийт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өргөдөл гомдлоос дийлэнхи нь нийслэйин төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэглээнд нэвтрүүлсэн нийслэлийн цахим үйлчилгээний eservice.ulaanbaatar.mn, Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний www.Smartcar.mn системийн ажиллагаа болон ашиглалттай холбоотой өргөдөл гомдлуудыг дийлэнх хувийг эзэлж байна. Байгууллагын хэмжээнд 2023 онд өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хугацаа хоцроосон зөрчилгүй ажилласан. | |
| 5.6 | Архив албан хэрэг хөтлөлт, https://edoc.ulaanbaatar.mn цахим системээр болон цаасаар ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийг эрчимжүүлж, холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллах | - | Албан бичгийн шийдвэрлэлт, хувь | 97,24% | 100% | Архивын Ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар", Стандарчлал Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Цахим баримт бичгийн солилцоо" стандарт /MNS ISO17933:2008/, 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт" /MNS 5140-1:2011, MNS5140-2:2011, MNS 5140-3:2011/-ын хэрэгжилтийг хангажБайгууллагын хэмжээнд архив албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн https://edoc.ulaanbaatar.mn цахим системд 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар нийт 894 албан бичиг ирснээс хариутай 175, хариугүй 715 албан бичиг ирснийг бүртгэн газрын даргаар цохуулж холбогдох албан хаагчдад шилжүүлэн түргэн шуурхай шийдвэрлэж, хариугүй бичгийн хаалтын хувь 99.64, хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 98.54 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувьтай байна. Мөн газрын хэмжээнд нийт 535 албан бичгийг цахимаар болон цаасаар боловсруулж аж, ахуй нэгж, байгууллагад https://edoc.ulaanbaatar.mn систем, шуудангаар хүргүүлж ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” А/453 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын хэмжээнд албан хаагчид албан бичиг боловсруулахдаа архив, албан хэрэг хөтлөлтийн Edoc системээр боловсруулж, тоон гарын үсэг ашиглан илгээх бүрэн боломжтой болж албан бичгийн харилцаа 100% цахимжсан. | |
| **Гүйцэтгэлийн дундаж хувь** | | | | | | | **92.7%** |

ТӨЛӨВЛӨГӨӨ ХЯНАСАН: **ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ**

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ .............................. /Х.НЯМБААТАР/
(албан тушаал) (гарын үсэг)

.......................
(огноо)

ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАЙЛАГНАСАН: **ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ**

НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА .............................. /Б.ДАВААНЯМ/
(албан тушаал) (гарын үсэг)

2023.12.11
(огноо)

9022011249
9167269 СБТ17687